

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.07

### Онцлох мэдээ

- АНУ-ын фермийн бус салбарын цалингийн цэсийн мэдээгээр 1-р сард 467,000 ажлын байр нэмэгджээ. Мөн ажилгүйдлийн түвшин 12-р сарын 3.9%-иас 4.0% болж өссөн байна.
- Баасан гарагийн тоон мэдээгээр Евро бүсийн жижиглэн худалдааны борлуулалт Зул сарын баярын худалдан авалтын улирлаас үл харгалзан 12-р сард төсөөлж байснаас сул байлаа. Тодруулбал, 12-р сард 3.0% буурсан бол жилийн байдлаар 2.0% өсжээ.

### Валютын зах зээл

Өнгөрсөн долоо хоногт Европийн төв банкнаас бодлогоо чангатгаж, хүүг өсгөх хандлага ажиглагдсанаар өнөөдөр өглөө евро Баасан гарагт тогтоосон 3 долоо хоногийн дээд цэгтэй ойролцоо байна. Гэхдээ Холбооны Нөөцийн банк хүүг өсгөж, ам.долларыг дэмжих нь тодорхой байгаа энэ үед еврогийн богино хугацааны өсөлт нь цаашид үргэлжлэхгүй байх гэж шинжээчид хэлэв. Еврогийн ханш 1.1451-р арилжаалагдаж буй нь Баасан гарагийн дээд цэг 1.4183-с холгүй байна. Иен 115.16, фунт стерлинг 1.35310-р арилжаалагдаж тус бүр сүүлийн арилжааны хүрээний дунжийг барьж байна.

ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин Хятадын удирдагч Ши Жиньпиньтэй уулзах үеэрээ хийн шинэ хэлэлцээрийн талаар ярилцсанаар рубль 1 гаруй хувь чангарч, эрчим хүчний салбарын хувьцаанууд өсжээ. Рубль 1 хувиар чангарч 76.68-тай тэнцэж 15 сарын доод цэг 80.4125-с холдож эхэллээ.

### Алтны зах зээл

Даваа гарагт алтны ханш өслөө. АНУ-ын ажлын байрны тайлан хүлээлтээс илүү сайн гарсны дараа АНУ-ын засгийн бондын өгөөж нэмэгдэж, үүссэн дарамт болон инфляцийн эрсдэлийг бууруулахаар алтны эрэлт нэмэгдэж ханш өслөө. 1 унц алтны спот ханш өглөөний байдлаар 0.2% өсөлттэй 1,810.38 ам.доллартай тэнцүү байсан бол АНУ-ын алтны фьючерс GCv1 0.2% өсөж 1,812.10 ам.доллар боллоо. Ингэснээр спот ханш өнгөрсөн Баасан гарагт хүрсэн долоо хоногийн дээд түвшинтэй ойрхон байна.

### Зэсийн зах зээл

Хэдийгээр Хятад улсад долоо хоногийн баярын амралт тохиож арилжааны хэмжээ бага байсан ч ам.долларын ханшийн сулрал, зэсийн нөөцийн бууралт зэрэг нь зэсийн ханшийг өсгөж, өнгөрсөн долоо хоногт ашигтай гаргажээ. Лондонгийн Металлын Биржийн 3 сарын хугацаатай зэсийн фьючерсийн үнэ 0.4% дээшилж 9,870 ам.долларт хүрснээр ханш тухайн долоо хоногт 4 орчим хувиар өссөн байна. ЛМБ-ийн баталгаажсан зэсийн нөөц 82,400 тонн болсон бөгөөд 2021 оны оргил үе 8-р сараас хойш 60 гаруй хувиар багасжээ.

Валют	Ханш	24ц өөрч.	
EUR/USD	1.1428	-0.18%	
USD/CNY	6.3644	-0.09%	
USD/RUB	75.8398	0.04%	
USD/JPY	115.28	0.02%	
USD/KRW	1199.85	0.23%	
AUD/USD	0.7074	0.00%	
GBP/USD	1.3519	0.00%	
Индекс	Нэгж	24ц өөрч.	
Dow Jones	35089.7	-0.06%	
S&P 500	4500.5	0.52%	
NASDAQ	14098.0	1.58%	
FTSE 100	7516.4	-0.17%	
Nikkei 225	27203.7	-0.86%	
DAX	15099.6	-1.75%	
Hang Seng	24376.9	-0.80%	
Метал	Ханш (USD)	24ц өөрч.	
Алт	1809.94	0.09%	
Мөнгө	22.75	1.05%	
Нүүрс (Чин хуанг дао)	153.51	0.00%	
Зэс (LME)	9841.5	0.09%	
Төмрийн хүдэр	817.50	2.51%	
Газрын тос (NYME)	91.39	-1.00%	
LIBOR	Хүү	24ц өөрч.	
US 1M LIBOR	0.12%	3.59%	
US 3M LIBOR	0.34%	7.62%	
US 6M LIBOR	0.56%	5.05%	
US 12M LIBOR	1.00%	5.84%	
Бонд	Хүү	24ц өөрч.	
US Treasury 10Y	1.90%	-0.19%	
UK Treasury 10Y	1.41%	3.14%	
GE Treasury 10Y	0.21%	43.36%	
JP Treasury 10Y	0.20%	1.52%	
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж 24ц өөрч.
МИК 2022	9.75%	1/29/2022	11.14% 0.00%
Чингис	5.13%	12/5/2022	3.01% 0.02%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.67% -0.08%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	3.91% 0.34%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.99% -0.19%
ММС	9.25%	4/15/2024	22.09% 0.15%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.14% 0.00%
Номад	5.13%	4/7/2026	4.74% -0.14%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.92% -0.30%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.37% -0.35%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.03% 0.00%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	18.59	4.91%
Mongolian Mining Corp	1.7	14.86%
Erdene Resource Dev	0.38	-2.56%
Centerra Gold	10.36	4.23%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд					
Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
GE Industrial Orders MM	2.8%	0.5%	3.7%
US Average Earnings YY	5.7%	5.2%	4.7%
US Unemployment Rate	4.0%	3.9%	3.9%
US Non-Farm Payrolls	467k	150k	199k

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
CN Caixin Services PMI	9:45	-	53.1
GE Industrial Output MM	15:00	0.4%	-0.2%
UK Halifax House Prices MM	15:00	-	1.1%

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
CA Trade Balance C\$	21:30	2.62B	3.13B
US International Trade \$	21:30	-83.0B	-80.2B
JP Current Account NSA JPY	7:50	73.5B	897.3B

## Газрын тосны зах зээл

Газрын тосны үнэ өссөн хэвээр байна. Хөрөнгө оруулагчид эрэлт өндөр түвшинд хадгалагдаж нийлүүлэлт хомсдолтой хэвээр байна гэж үзэж байна. Brent газрын тосны үнэ 0.6 хувь өсч 93.87 ам.долларт арилжаалагдаж байна. 2014 оноос хойших хамгийн өндөр үнэ буюу 94.00 ам.доллар хүрч 92.47 ам.доллар хүртэл буураад эргэн өслөө.

## Бондын зах зээл

Дэлхийн бондын ханшийн уналт Даваа гарагт үргэлжилсээр байна. АНУ-ын ажлын байрны мэдээ хүлээлтгүйг давуулан биелүүлснээр бодлогын хүүг огцом нэмэх хүлээлт Дэлхий даяар үүсгэснээр Австралийн бондыг их хэмжээгээр зарж эхэллээ. Баасан гарагт АНУ-ын засгийн өгөөж огцом өссөний дараа Австралийн богино хугацааны өгөөж 3 жилийн дээд цэг рүү үсэрлээ. АНУ-ын засгийн бондын ханш Баасан гарагийн уналтаа тогтоосон бөгөөд 10 жилийн өгөөж нь 1 нэгж буурч 1.90% боллоо.

## Хөрөнгийн зах зээл

Цагаан сарын амралтын дараагаар БНХАУ-ын хөрөнгийн зах зээл өндөр өсөлт үзүүлж байна. Хонг Конгийн хөрөнгийн зах зээлд шинээр арилжаалагдаж эхэлсэн хувьцааны өсөлтүүд болон тус улсын технологийн салбарын зохицуулалтыг зөөллөх мэдээ гарснаар хөрөнгийн зах зээл өслөө. Хөрөнгө оруулагчид энэ жил Холбооны Нөөцийн банкнаас 5 удаа хүүг өсгөн гэсэн хүлээлттэй байна.

### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.